



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах,
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Пүрэв овогтой Лхагвасүрэнг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Австрали Улсын Сиднейн их сургуулийн магистрантурт боловсрол судлалын чиглэлээр 3 жилийн хугацаагаар, Хоролсүрэн овогтой Ундрааг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр, Даваадэлгэр овогтой Батзоригийг Улсын мэргэжлийн хяналтын газрын захиалгаар АНУ-ын Стратфорд их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Цэдэвсүрэн овогтой Батмөнхийг Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын захиалгаар АНУ-ын Денверийн их сургуулийн магистрантурт мэдээллийн технологийн чиглэлээр, Энхтөмөр овогтой Уранбилэгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Австрали Улсын Эдит Ковен их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн удирдлагын чиглэлээр, Баттулга овогтой Дөлгөөнийг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын захиалгаар АНУ-ын Сиэтлийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Энх-Амгалан овогтой Баясгаланг Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар АНУ-ын Колорадогийн техникийн их сургуулийн магистрантурт эрүүгийн эрх зүйн чиглэлээр, Бямбадорж овогтой Цэнгүүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Кларксоны их сургуульд физикийн инженерийн чиглэлээр, Бат-Өлзий овогтой Баттогтохыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар БНСУ-ын Сөүлийн үндэсний их сургуульд эдийн засгийн удирдлагын чиглэлээр, Ганбаатар овогтой Батхуягийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн Сингапур дахь салбар сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

~~2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 317 дугаар тушаалын Баасанжав овогтой Оюунцэцэгтэй холбогдолтой~~

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалын дугаар 251

02 10 11

хэсгийн "АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт" гэснийг "АНУ-ын Калифорнийн Улсын их сургуулийн магистрантурт" гэж өөрчилсүгэй.

3. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасгай.



Нансалмаа

Н.БОЛОРМАА